

**МОНГОЛ—АМЕРИКИЙН ХАРИЛЦААНЫ
ТУУЛСАН ЗАМ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ**

Ц. Пунцагноров*

1. Богд хаант Монгол улс АНУ-тай харилцаа тогтоохыг эрмэлзсэн нь (1911-1919)

Монгол-АНУ-ын хооронд эдийн засаг, улс төрийн харилцаа үүсэн тогтох бодит нөхцөл бололцоо XIX зууны эцэс, XX зууны эхээр анх бүрэлдсэн юм. Өрнөдийн хөрөнгөтөн орнууд хоцрогдсон манжийн Дайчин гүрний томоохон хэсэг Хятадыг хүч хэрэглэн хараат байдалд оруулсны дараахан АНУ нь «Нээлттэй хаалганы» үзэл бодлогыг баримтлан мөн Дайчин гүрний эрхшээлд байсан Монголын зах зээлд нэвтрэн орж эхэлсэн билээ. Америкийн пүүсүүд, хятадын, заримдаа оросын худалдаачдыг зуучлагч болгон монголын мал аж ахуйн түүхий эд, ангийн үсийг дэлхийн зах зээлд гаргахын зэрэгцээ АНУ-д үйлдвэрлэсэн даалимба, цууямбуу гэх зэрэг барааг авчиран борлуулдаг байв. Америкчууд хуурай газрын замыг бодвол хоёр дахин хямд далайн замыг ашиглаж байсан учир тэдгээртэй өрсөлдөгч орос худалдаачдыг монголоос шахан зайлуулж байв. Энэ зууны эхээр монголд ажиллаж байсан Москвагийн худалдааны шинжилгээний ангийн тайлан: «Манай үйлдвэрийн бараа, боловсруулсан арьс, төмөр эдлэл болон бусад таваарууд Монголын зах зээлээс аажим аажмаар шахагдан Хятад, Америк...-т үйлдвэрлэсэн бараа таваараар солигдож байна» гэжээ. Мөн тэр үед Монголд ирж байсан ангийн ажиглагч О. Бланд: «Монголтой хийдэг Оросын худалдаа сүүлийн арван жилд Герман, Америкийн өрсөлдөөнөөс болж буурчээ» гэж бичсэн байна.²

Монголоос Америкт гаргадаг түүхий эд нь. эхлээд Хятад, Оросын худалдаачдын гараар дамждаг байсан бол XIX зууны эхээр Америкийн зарим пүүсүүд монголд төлөөний хүнээ суулган барааг монголчуудаас шууд биеэ дааж худалдан авдаг болжээ.

1909 онд Жанчхүү дахь Америк консул Стрейт Монголд АНУ-ын эдийн засгийн байр суурийг бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулж төрийн департаментын шийдвэрээр Хятадын (Дайчин гүрний) талтай хэлэлцээ хийж байжээ³

Америкийн хөрөнгөтнүүд мал аж ахуйн бүтээгдэхүүнд анхны бо ловсруулалт хийх жижиг үйлдвэрүүдийг байгуулах, бас Монгол орны газрын баялгийг олзворлон ашиглахад оролцож эхэлжээ. 1900 онд Олон улсын хөрөнгөөр байгуулсан “Монголор» хэмээх алтны уурхайн тоног төхөөрөмжийг АНУ нийлүүлсэн юм. Мөн уурхайд АНУ-ын 46 инженер, техникч ажиллаж байв.⁴

Америкийн хөрөнгөтнүүд Монголын зах зээлийг эзэмшихийн тулд Хятадын далайн боомтуудыг Монголтой холбох төмөр зам тавих са нааг бүр XIX зууны сүүлчээс сэдэж байв. 1910 оны эхээр Хаант Орос улс Жанчхүүгээс Их Хүрээг дамжин Хиагт хүртэл төмөр зам тавихыг америкчуудад санал болгосон боловч их гүрнүүдийн хоорондын зөрчил маргаанаас болж уг санаа хэрэгжээгүй юм.⁵

АНУ нь XX зууны эхээр Монголын эдийн засагт давамгайлахын төлөө Хаант Орос болон Англи, Франц, Герман, Японтой өрсөлдөх болжээ.

*ШУА-ийн гишүүн, доктор, профессор, ДДОУС-ын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

Монгол дахь Манжийн ноёрхлыг 1911 онд түлхэн унагаасны дараа Монгол улсын хаанаар өргөмжлөгдсөн, Богд Жавзундамба хутагтын Засгийн газар тус улсын тусгаар тогтнолыг дэлхийн олон улсаар хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө шаргуу тэмцэхдээ АНУ-тай дипломат болон худалдааны харилцаа тогтоохыг эн тэргүүнд эрмэлзэв. Богд-хааны Засгийн газар Петербург, Бээжин дахь АНУ-ын дипломат төлөөлөгчийн газраар нь дамжуулж албан ёсны харилцаа тогтоох саналаа Вашингтонд удаа дараа (1913, 1914 онд) мэдэгдсэн юм.

АНУ-ын дипломатууд болон шинжээчид Монголд хүрэлцэн ирж улс төрийн байдлыг нь газар дээр нь судалж байснаас гадна хаант Орос, Хятад хоёр Монголын тусгаар тогтнолд яаж хандахыг нарийн ажиглаж байв. Тухайлбал, Хятад улсад АНУ-ын Элчин сайд, Төв Азийн судлагч, нэрт эрдэмтэн Рокхилль 1914 онд Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирж Богд хаанд бараалхан Монголын Ерөнхий сайд, Засгийн газрын бусад гишүүдтэй уулзсан юм. Гэвч АНУ-ын Засгийн газар Өрнөдийн бусад гүрний нэгэн адил Монголын тусгаар тогтнолд нааштай хандаагүй юм. Үүний нэг шалтгаан нь Монголтой шууд хил залгадаг Орос, Хятад хоёрын бодлоготой холбоотой байв.

Хэрэв хаант Орос улс Монголыг хамгаалалтдаа авч зөвхөн автономит эрхтэй улс болгохыг зорьж байсан бол БНХУ Өөрийгөө маңжийн Дайчин, гүрний эрх залгамжлагч хэмээн үзэж Монгол орныг Хятадтай нэгтгэн нийлүүлэх бодлого явуулж байв. АНУ тухайн цаг үед Хятадын бодлогыг дэмжиж байсан билээ.

1915 онд гурван улсын (Орос-Хятад-Монгол хэлэлцээний дүнд Орос, Хятад хоёр Монголын тусгаар тогтнолыг цуцлаж түүнийг Оросын хамгаалалттай (протекторат) Хятадын сюзеренитет эрх бүхий автономит улс хэмээн хүлээн зөвшөөрчээ. Богд хааны Засгийн газар «автономит» гэдэг томъёог бүрэн эрхт бие даасан байдал гэж ойлгож байгаага мэдэгджээ.

Автономит үед (1915-1919) Монголын эдийн засаг, соёлын гадаад харилцаа өргөжин харь орны, тэдгээрийн дотор АНУ-ын худалдаачид, эрдэмтэд, дипломатууд Монголд ирэх явдал мэдэгдэхүйц нэмэгдэв. Монголоос адуу, мал аж ахуйн түүхий эд, ангийн үсийг экспорт лон гаргадаг «Андерсен ба Мейер», «Монголиан Трейдинг компани» зэрэг Америкийн хэд хэдэн пүүс нээгдэв. Эдгээр компанид америкчуу даас гадна нэлээд тооны монгол, Хятад хөлсний ажилчин байв.

АНУ-ын пүүсүүд «Американ хашаа» буюу «Американ дэнж» гэж нэршсэн худалдааныг газрын байрыг (контор, дэлгүүр, склад) Нийслэл хүрээнд байгуулжээ. 1916 онд Нийслэлд анхны цахилгаан станц байгуулахад зарим тоног төхөөрөмжийг АНУ-аас авсан байна.⁶

Богд хааны Засгийн газар Америкийн «Андерсен ба Мейер» пүүстэй түншийн харилцаа тогтоож 30 мянган янчааныг 9 хувийн хүүтэй Зээлэн авч байжээ.⁷ Мөн тэр пүүс Жанчхүү-Нийслэл Хүрээний хооронд сар бүр 3 удаа авто тээвэр хийх эрх олжээ.

1917 онд Орос оронд ялсан Октябрийн хувьсгал Монголын гадаад, дотоод байдлыг эрс өөрчилжээ. Зөвлөлт Орос Улс хуучин хаант засгаас тулган хүлээлгэсэн тэгш бус гэрээ бичгүүдийг хүчингүй болгож Монголын тусгаар тогтнох эрхийг хүлээн зөвшөөрчээ. Гэтэл Бээжингийн эрх баригчид Орос улсын хаант засаг унасныг далимдуулан Монголын автономийг устгаж Хятадтай нэгтгэн нийлүүлэхийг шууд оролдов. Ийм ээдрээтэй цаг үед Богд хааны Засгийн газар болон нөлөө бүхий улс төрийн хүчний дотор Монголын үндэсний засаг төрийг авран хамгаалахад гадны ямар улсыг түшиглэх вэ гэдэг асуудлаар са-

нал хуваагджээ. Ардчилсан хувьсгалт үзэлтэй бичиг, цэргийн түшмэд болон хэсэг том феодалууд Зөвлөлт Орос улсын тусламж авахыг эрмэлзэж байв. Нөлөө бүхий зарим хүн ойр бөгөөд түргэнийг бодож эзэн хаант Япон улсын дэмжлэг гуйхыг санал болгоход Богд хаан Япон цэрэг Солонгосыг түрэмгийлэн харгисласныг дурдаад татгалзсан юм. Харин Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав зэрэг зарим том шар феодал Монголоос алс хол оршдог, хүчирхэг Америк улсыг түшиглэх санал гаргахад Богдхаан түүнийг дэмжин сайшаажээ. Ийм байр суурь нь юуны өмнө тайван биш байдалд орсон хоёр хөрш том гүрэн болон Азийн түрэмгий улсыг бараадахаас зайлсхийн найдвартай өөр хань холбоотныг олох гэсэн эрмэлзэлтэй холбоотой болов уу. Монголын эрх баригчдын дотор АНУ-ыг түшиглэх гэсэн хандлага хүчтэй болоход америкийн Ерөнхийлөгч Вудро Вильсоны 1918 онд тунхагласан дэлхийн дайны дараа энх тайвныг сахин хамгаалах үзэл бодлого, нөлөөлсөн бололтой. В. Вильсон бага буурай орны улс төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилт дэвшүүлсэн нь Монголчуудын тусгаар тогтнолын төлөө тэмцэлд нь АНУ дэмжлэг үзүүлнэ гэсэн найдлага төрүүлжээ.

1919 онд Монголд амьдарч байсан Польш улсын (хуучин хаант Оросын иргэн М. А. Воллсович ерөнхий сайд Намнансүрэнд бичсэн захидалдаа В. Вильсоны үзэл бодлогын дагуу «бусдын хараат биш, өөрийн тусгай эрхтэй болох» хүслээ АНУ-ын болон Өрнөдийн орнууд, түүнчлэн Орос, Хятадын төлөөлөгчид мэдүүлж АНУ-ын Конгрессоор Монголын асуудлыг хэлэлцүүлэхийг зөвлөж байсан байна.⁸

Монголын эрх баригчдыг АНУ-ын захиргаатай холбох гэж америк «Андерсон ба Мейер» пүүсийн төлөөлөгч Франц Ларсон багагүй хүчин чармайлт гаргасан билээ. Ларсон XIX зууны сүүлчээр монголд анх хүрэлцэн ирж Ар, Өвөр монголын нутгаар олон жилийн турш хэсүүлэн наймаа хийсний дүнд монгол хэлийг төгөлдөр эзэмшжээ. Монголд байх хугацаандаа Ларсон Богд хаан болон бусад эрх баригчидтай дотно харилцаа тогтоосон байв. Монголын эрх ашгийн төлөө зүтгэснийг нь тэмдэглэж Богд хаан түүнийг гүн хэргэмээр шагнажээ.

Ларсоны тухай Оросын хэвлэлд бичихдээ тэр нь Монгол ноёдыг Хятад руу хандуулахыг оролдсон «Юань Ши-Цайн тагнуул төлөөлөгч» мөн гэж тэмдэглэж байжээ.⁹

Ф. Ларсон Богдхааны Засгийн газраас АНУ-тай харилцаа тогтоох гэсэн эрмэлзлэлийг нь элдвээр өөгшүүлэн дэмжиж АНУ-ын албаны хүмүүстэй удаа дараа уулзаж хэлэлцээ хийх, Богдын хүсэлтийг англи хэлэнд хөрвүүлэхэд шууд гар биеэр оролцон тусалж байсан юм.¹⁰

1920 онд Нийслэл хүрээнд дараа дараагаараа хүрэлцэн ирсэн америкийн дипломатч Эберхардт, Сокобин нартай Жалханз хутагт, Дилав хутагт нар Богд хааны даалгавраар уулзаж Монгол улсыг сэргээхэд АНУ-ын дэмжлэгийг хүсчээ.

Богд хаан мөн оны дундуур хоёр хутагтыг Бээжинд томилон явуулж АНУ-ын Элчин болон цэргийн атташед мөн хүсэлтээ давтуулжээ.¹¹

Гэвч АНУ-ын Засгийн газар тэр үед Монголыг Хятадын нэг хэсэг гэж үзэх бодлого баримтлан Богд хаанд албан ёсны ямар нэгэн хариу өгөөгүй юм. Ийм ч учраас Богд хаан Зөвлөлт Орос улсаас цэргийн тусламж гуйхыг эрмэлзэж байсан Монголын ардын намын төлөөлөгчдөд өөрийн тамгатай бичгийг өгсөн байна.

1920 оны сүүлчээр барон Унгерны Оросын цагааны цэрэг Монголд цөмрөн орж Хятадын гаминтай байлдах үед америкийн пүүсүүд

түрэмгийлэгчдийн өдүүлсэн хэрэг явдалд үл оролцон аль алинд нь машин тэрэг гаргаж өгөхөөс татгалзсаныг тэмдэглэх хэрэгтэй.¹²

Ардын түр Засгийн газраас Хиагтыг гамингаас чөлөөлөхөд Хятадын цэргийн эрхтнүүд Наймаа хотын энгийн номхон ардуудыг бүрэлгэн сүйтгэсэн явдлыг нягтлан шалгах олон улсын чанартай комиссыг 1921 оны 3 дугаар сарын 19-нд эмхлэн байгуулахад бүрэлдэхүүнд нь Монголд амьдарч байсан Орос, Дани, Унгарын иргэдийн зэрэгцээ АНУ ын (Хойт Америкийн Холбоот улсын иргэнийг оруулсан билээ.¹³

2. Ардын хувьсгал ба Монгол-Америкийн харилцаа (1921—1986)

1921 онд Монголд эзэрхэг түрэмгий, феодалыг эсэргүүцсэн хувьсгал ялж тусгаар тогтносон шинэ Монгол улс үүссэний дараа ардын засаг нь дэлхийн гол гол орнууд, тэдгээрийн дотор АНУ-д хандаж - дипломат болон худалдааны харилцаа тогтоох санал дэвшүүлсэн билээ. Гэтэл АНУ, Өрнөдийн бусад гүрэн Монголын төрийн тусгаар тогтнолыг үгүйсгэн Хятадын эзлэн түрэмгийлэх бодлогыг дэмжсэн юм. Гэлээ ч гэсэн Монгол-Америкийн худалдаа харилцаа өргөжин бэхжиж байв. 1921 онд АНУ-ын Конгресс Монголоос ноос худалдан авахад саад уч руулж байсан гаалийн татварыг өөрчилж Монголтой худалдааны харилцааг хөгжүүлэх зорилго бүхий тусгай шинжилгээний анги явуулжээ.¹⁴ 1922 онд Монголд англи-америкийн 5 пүүс байсан бол 1924 онд 62 болон өсчээ.¹⁵ 1925 онд америкчууд Монгол оронд 4,5 сая янчаан (мексик-доллар) -ы хөрөнгөтэй байв. «Ах дүү Бреннер», «Қауфман энд Қо», «Джозеф Ульманы америкийн хувь нийлүүлсэн нийгэмлэг» гэх зэрэг америк пүүсийн жилийн гүйлгээ олон зуун янчаан хүрч байв.¹⁶

Зөвхөн 1925 онд америкчууд Хайлар хотоор дамжуулан 150 мянган пүү ноосыг Монголоос гаргажээ.¹⁷ 1927 онд Монголоос экспортлодог түүхий эдийн 30 хувийг АНУ-д гаргадаг байв. АНУ нь монголын экспортод ЗХУ-ын дараа, хоёрдугаар байранд оржээ.¹⁸

«Стандарт ойл компани Нью-Йорк», «Бритиш-американ Тобакоу Ко», «Мастерд энд Ко», «Мыючуал Лайф Иншуранс Ко», «Андерсен, Мейер» Нью-Йорк хотын хэд хэдэн банкйн газрууд монголын зах зээлд аажмаар нэвтрэн орж байв.¹⁹

1922 онд америкчууд үнэт металлыг олзворлон гаргах концессийн тухай хэлэлцээг Монголын Засгийн газартай хийж байжээ.²⁰ Америкийн хөрөнгөтнүүд Монголд алтны уурхайн концесс авах сонирхолтой байсан тухай Улсын Их Хуралд БНМАУ-ын Засгийн газраас оруулсан илтгэлд өгүүлсэн байдаг.²¹

1923 онд америкчууд Жанчхүү- Улаанбаатарын хооронд тогтмол ачаа тээвэрлэж 110 автомашин хөдөлгөж байв.²²

БНМАУ 30-аад он хүртэл АНУ-ын «Форд», «Шилэн Найм» гэж нэрлэгдсэн, («Бьюик», «Додж», «Шевролет») «Шавар лент» гэж нэршсэн) гэх мэтийн автомашиныг худалдан авдаг байв.

Монгол дахь гадаадын пүүсүүдийн дотор америкчууд ихээхэн нэр хүндтэй болсон бөгөөд 1922 онд Нийслэл хүрээнд хийсэн гадаадын пүүсүүдийн төлөөлөгчдийн хурлаас америк «Альберт Гершкович хүүтэйгээ» гэдэг пүүсийн төлөөлөгчид Худалдааны танхимын дүрмийг зохиож итгэмжлэгдсэн хүний хувьд Монголын захиргаанд танилцуулахыг даалгажээ.²³

Ийнхүү ардын хувьсгалын дараах үеийн АНУ-ын улс төрийн бодлогын ерөнхий чиг шугам нь ЗХУ-тай өрсөлдөн Монголын зах зээл дээр эдийн засгийн байр сууриа бэхжүүлэхэд оршиж байв.

Хувьсгалын дараа АНУ-Монгол хоёр шинжлэх ухааны салбарт ч харилцаатай байлаа.

Америкийн эрдэмтэд, байгалийн түүхийн суурь судалгааг үндэслэн Монгол орон бол эрт галавын амьтад болон хүний гарал үүслийн өлгий нутаг мөн гэсэн таамаглалыг 19-р зууны сүүлчээр анх дэвшүүлсэн билээ. Энэхүү онолын магадлагааг нотлох зорилгоор Нью-Йорк хотын Байгалийн түүхийн музейгээс зохион байгуулсан Төв Азийн шинжилгээний анги 20-иод онд Монголын говь нутгаас эрт дээр үеийн амьтдын ясыг илрүүлж гайхамшигт нээлт хийжээ. Уг шинжилгээний ангид оролцсон Г. Осборн, Р. Ч. Эндрьюс, В. Гренжер мөн бусад эрдэмтэн 13 боть зохиол, олон тооны өгүүлэл хэвлэн нийтэлж дэлхийн шинжлэх ухааны санд үнэтэй хувь нэмэр оруулжээ. Эрдэмтэн Н. Нельсон америкийн индианчуудын гарлыг энэ тивд нүүж очсон эртний Монголчуудтай холбож тайлбарлажээ. Түүнээс гадна америкийн эрдэмтэд 20-р зууны эхний үеийн монголчуудын аж амьдрал ёс заншлыг харуулсан кино зураг авч түүхийн чухал баримт болгон үлдээснийг хожим Байгалийн музейн удирдлагаас БНМАУ-д бэлэглэсэн юм.

Тухайн үеийн тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан америкийн эрдэмтдийн туурвисан дээрх бүтээлээс орчуулж Монголын олон нийтийн хүртээл болж чадаагүй байгаа нь харамсалтай.

Ардын хувьсгалаас хойш АНУ-ын дипломат албаны хүмүүс ч Монголд үзэгдэж байв. Тухайлбал, АНУ-ын Бээжин дахь цэргийн атташе Жозеф Стиллүэлл 1923 оны 6-р сард Нийслэл хүрээнд ирсэн байна.²⁴

БНМАУ-ын Засгийн газрын удирдлагад орж байсан Н. Жадамба 1925 онд Баянтүмэнд нээгдсэн худалдааны яармагт ирсэн Харбин хот дахь америкийн консултай уулзаж хоёр орны харилцааг хөгжүүлэх тухай ярилцаж байжээ. Түүнээс хойш Монгол-Америкийн албаны хүмүүсийн хоорондох ямарваа нэгэн харилцаа хэсэг үе зогссон байна.

Хөрөнгөтний биш хөгжлийн замыг заасан МАХН-ын III их хурлаас (1924) хойш БНМАУ нь гадаадын хөрөнгөтнүүдийг эдийн засгийн болон захиргааны янз бүрийн аргаар шахан зайлуулах, эдийн засгийн үндсэн салбаруудыг улсын гарт төвлөрүүлэх бодлого явуулж 1929 онд гадаад худалдааны онц эрхийг тогтоосны дүнд 20-иод оны сүүлч, 30 аад оны эхээр Монгол-Америкийн худалдаа-эдийн засгийн харилцаа тасарч Монгол дахь америкийн пүүсүүд хаагдав.

1931 онд эзэрхэг түрэмгий Япон Зүүн Хойт Хятад руу дайран довтолж улмаар ЗХУ, БНМАУ-д шууд аюул занал учруулах болжээ. Алс Дорнодод дайн түрэмгийллийн голомт ийнхүү үүссэнтэй холбогдуулж АНУ-ын гадаад бодлого Монголын цэрэг-стратегийн ач холбогдлыг сүрхий анхаарах болж түрэмгийллийн эсрэг тэмцэлд Монгол улсын гүйцэтгэж буй үүрэг, хэтийн төлөв зэрэг асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийх болжээ. Монголын талаар АНУ-ын баримтлах бодлогыг төлөвлөн боловсруулахад америкийн төрийн болон олон нийтийн зүтгэлтэн, Монгол болон Алс дорнодын түүхээр мэргэшсэн эрдэмтэн Оуэн Латтимор жинтэй хувь нэмэр оруулжээ. О. Латтимор БНМАУ-ын тухай хэд хэдэн зохиол бүтээж Монголын үлгэр жишээг үндэс болгон ЗХУ-ын «дагуул» улсын тухай онол гаргажээ.

Монголын нутагт халдан довтолсон Японы түрэмгийлэгчдийг Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчээр Халх голын орчим бут ниргэсэн нь АНУ-д гүнзгий сэтгэгдэл төрүүлжээ. О. Латтимор: «1939 оны олон улсын байдалтай холбож үзвэл энэ байлдаан (Халх голын П.) нэн чухал ач холбогдолтой байв. Хэрэв Япончууд амжилт олсон бол тулгаран ойртож байсан дэлхийн хоёрдугаар дайны бүхий л шинж байдал нь өөр болсон байж магадгүй юм гэж Халх голын ялалтын үр шимийг үнэлсэн юм.»²⁵

(Үргэлжлэл бий)

1. Московская торговая экспедиция в Монголию Москва, 1912, 12 дугаар талд
2. P. Band, Recent events and personal, politics in China London, 1912, 352 дугаар талд
3. Pacific historical review, Vol. XXXIV, № 1, 1955, p. 56, 57.
4. Вестник Азии 1912 № 11—12 с. 76
5. БНМАУ-ын түүхийн архив (ф—305—1) х. н 823
Бадаргуут төрийн эдийн засаг ф. 1, т. II, X. н 17
6. Нийслэл хүрээний сонин бичиг, 1917 оны 2-р сарын 9 № 46
7. С. R. Bawden The Modern History of Mongolia 1968, p. 164.
8. БНМАУ-ын түүхийн төв архив ф1-4, т. I, х/н 521
9. «Новое время» 1913, 23 декабря (5 января)
10. Ф. Ларсон. «Уолл Стритийн» тагнуул төлөөлөгч хэмээгдэн БНМАУ-аас 1930 онд хөөн зайлуулагджээ.
11. Diluv Khutagt. Memoirs and Autobiography of Mongol Buddhist Reincarnation in Religion and Revolution Wiesbaden, 1982 p. 162
12. Ц. Батбаяр. Кодама Мицуи пүүс. Хүрээнд байсан Япончууд. 1911—1921, УБ. 1993, 43 . дугаар талд
13. БНМАУ-ын түүх, III боть, 1969
14. «Новый Восток», 1925, № 10—11, с. 164
15. Протоколы I Великого Народного Хурала МНР, УБ, 1925, 131— 135 талд
16. Хозяйство Монголии, 1926, № 1, 60-61 тал
17. «Экономический бюллетень», 1925, № 40, 3 дугаар талд
18. G. Murphy. The Economic Development of Outer Mongolian Economy in Recent Times. Ann arbor Microfilms, с 226
19. Монгольский сборник М. 1959, с 135
20. Жизнь Бурятин м. 24 № 4—5, с 5
21. «Заря» 7. IX. 1929 :
22. «Известия Улан-Батор хот» 8, XII, 1926 № 79 (3442)
23. «Бюллетень МОНТА», 13, 1, 1923
- *«Ардын эрх», 1993. V. 5 № 39, 3-р талд
24. R. Rupen. How Mongolia is a really ruled. Stanford. 1979. p. 123
25. O. Zattimore. Nomads and Comissars № 4. 1962. p. 1342135